



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Хэнтий аймаг дахь Прокурорын газар, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 44,000,000.00 (дөчин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, “Ховд АЗЗА” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Сансархүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө шилжүүлэх, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2024 оны 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.4. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132000132

4-r huraldaan.docx



УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХАРЪЯА ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ХОВД АЗЗА" ТӨХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын болон арлын дугаар.	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Хөрөнгө эзэмшигч байгууллагын нэр
1	Ниссан патрол, суудлын, арлын дугаар JN1TCSY61Z0581002, улсын дугаар 0800ДГО	2011	189,000	22,000,000.00	1	10,000,000.00	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Прокурорын газар
2	Ниссан патрол, суудлын, арлын дугаар JN1TCSY61Z0580847, улсын дугаар 5641ХЭҮ	2011	185,000	22,000,000.00	3	15,000,000.00	Хэнтий аймаг дахь Прокурорын газар
НИЙТ ДҮН				44,000,000.00		15,000,000.00	
				(дөчин дөрвөн сая)		(арван таван сая)	